

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДААНЫ ШИЙДВЭР

2022 08 сарын 11 өдөр

Дугаар 04/01

Арвайхээр сум

Хэлэлцсэн нь

- 1 ТУЗ-ийн дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төсөл
- 2 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын албан тушаалын тодорхойлолтын төсөл
- 3 Салбарын хөгжлийн бодлого, салбар дах шинэчлэл-Гүйцэтгэлтийн санхүүжилтийн талаарх танилцуулга
- 4 Төлөөлөн удирдах зөвлөлтэй холбогдох хууль эрх зүйн орчин
- 5 Гүйцэтгэлийн санхүүжилт ба стратегийн худалдан авалт сургалт
- 6 Эмнэлгийн хамт олонтой уулзалт хийх

Шийдвэрлэсэн нь:

- 1 Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүрэм, 2022-2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төсөлд ТУЗ-ийн гишүүдээс гарсан саналыг тусган тогтоолын төсөл боловсруулан 2022 оны 08 дугаар сарын 15-ны дотор батлуулахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Сумъяад даалгасугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын Албан тушаалын тодорхойлолтод ТУЗ-ийн гишүүдээс гарсан саналыг тусган эцэслэн боловсруулж 2022 оны 8 дугаар сарын 19-ний дотор батлуулахыг ТУЗ-ийн гишүүн Б.Одончимэгт даалгасугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс гарсан саналын дагуу ТУЗ-ийн гишүүдэд чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах сэдэв, нэрс, хугацааг авч нэгтгэн ТУЗ-ийн хуралд танилцуулахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Сумъяад үүрэг болгосугай.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны онцлогтой холбогдуулан БОЭТ-д өгсөн үүрэг чиглэлд байнгын хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн гишүүн Т.Мөнхбатад даалгасугай.
5. ТУЗ-өөс эмнэлгийн хамт олын дунд сэтгэл ханамжийн судалгаа явуулах бэлтгэл ажлыг 2022 08 дугаар сарын 26-ны дотор хангаж ТУЗ-ийн гишүүдэд танилцуулахыг ТУЗ-ийн гишүүн Т.Төмөртогтоо, Г.Энхтуяа, Б.Энхцогт нарт даалгасугай.
6. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийг дагуу БОЭТ-д үүрэг чиглэл өгөх тухай албан бичгийг 2022 оын 8 дугаар сарын 17-ны дотор хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Сумъяад үүрэг болгосугай.
7. БОЭТ-ийн гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалт зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган 2022 оны 9 дүгээр сарын 10-ны дотор зарлахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Сумъяад үүрэг болгосугай.



Scanned with
MOBILE SCANNER